

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Б. Ариунтуяа

Утас:99036832 Цахим хаяг: Ariuntuya@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Б. Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: mydagmaa0208@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.08.25 № 01/176

танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ШИНЭ-ИДЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б.ДОГСМАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 12,836.8 мянган төгрөгийн авлагатай, орон нутгийн төсөвт хасах тодотгол хийснээс түлш халаалтын зардлын 19,714.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 131,021.9 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчлийг илрүүлж 126,396.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Шинэ-Идэр сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг 84,6 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp of the State Audit Agency (АДБОУС) is placed over the signature. The stamp contains the agency's name in Mongolian and Cyrillic, along with a central emblem. The signature is written in black ink over the stamp.

А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	378,041,298.57	160,297,179.58
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	35,252,725.84	37,602,896.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	35,252,725.84	37,602,896.24
3121	Төгрөг	35,252,725.84	37,602,896.24
31211	Төрийн сангийн харилцах	35,252,725.84	37,602,896.24
33	АВЛАГА	225,439,200.23	13,165,932.97
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,100.76	329,100.76
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	225,410,099.47	12,836,832.21
35	БАРАА МАТЕРИАЛ	117,349,372.50	109,528,350.37
351	Түүхий эд материал	43,867,907.58	43,177,579.67
35130	Эм боох материал	43,867,907.58	43,177,579.67
354	Хангамжийн материал	73,481,464.92	66,350,770.70
35420	Аж ахуйн материал	20,611,522.46	20,120,022.46
35430	Сэлбэг хэрэгсэл	1,500,000.00	2,500,000.00
35450	Барилгын засварын материал	202,890.00	202,890.00
35460	Хүнсний материал	13,566,446.00	8,022,219.50
35470	Бусад хангамжийн материал	36,754,526.46	35,505,638.74
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,857,672,907.46	1,751,655,076.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,857,672,907.46	1,751,655,076.92
392	Биет хөрөнгө	1,835,350,907.38	1,729,671,076.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,615,871,546.28	1,615,871,546.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-217,260,704.40	-255,479,261.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,921,714.00	67,921,714.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46,804,004.70	-57,663,680.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	587,247,618.01	581,415,379.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-272,539,904.26	-311,263,738.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,275,400.00	80,131,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,666,984.70	-30,172,187.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	62,306,459.80	62,306,459.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,000,232.65	-23,396,454.77
393	Биет бус хөрөнгө	22,322,000.08	21,984,000.04
39301	Програм хангамж	1,690,000.00	1,690,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-175,999.92	-513,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	20,808,000.00	20,808,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,235,714,206.03	1,911,952,256.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,577,985.71	52,446,472.41
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,577,985.71	52,446,472.41
413	Өглөг	30,577,985.71	52,446,472.41
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	1,562,493.41
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,577,985.71	25,365,979.00
4136	Бусад өглөг	0	25,518,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	25,518,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,205,136,220.32	1,859,505,784.09
51	Засгийн газрын хувь оролцоо	2,205,136,220.32	1,859,505,784.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	435,284,554.00	435,284,554.00
51101	Өмч: - төрийн	435,284,554.00	435,284,554.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,680,796,209.61	1,335,165,773.38
51210	Өмнөх үеийн үр дүн	1,680,796,209.61	1,680,796,209.61
51220	Тайлант үеийн үр дүн	0	-345,630,436.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	89,055,456.71	89,055,456.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,235,714,206.03	1,911,952,256.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,549,017,880.20	1,531,751,721.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	192,616,220.00	156,415,557.26
120	Нийтлэг татварын бус орлого	192,616,220.00	156,415,557.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,602,000.00	120,268,783.00
120017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	24,840,446.00	13,674,734.26
120018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	62,173,774.00	22,472,040.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,356,401,660.20	1,375,336,163.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,839,200.00	60,924,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,839,200.00	60,924,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,283,562,460.20	1,314,411,363.80
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,283,562,460.20	1,314,411,363.80
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,410,576,913.79	1,873,892,407.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,410,576,913.79	1,873,892,407.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,334,602,071.79	1,751,473,335.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,264,491.52	1,174,625,294.16
210101	Үндсэн цалин	485,812,591.29	590,096,157.04
210102	Нэмэгдэл	296,218,010.49	436,648,151.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,404,000.00	49,641,600.00
210104	Урамшуулал	46,829,889.74	98,239,385.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,934,200.00	153,727,201.70
210201	Тэтгэврийн даатгал	94,193,000.00	104,926,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,435,300.00	11,604,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,217,600.00	5,802,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,217,600.00	5,802,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,870,700.00	25,591,201.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,111,058.00	71,916,794.00
210301	Гэрэл, цахилгаан	5,403,670.00	7,566,993.00
210302	Түлш, халаалт	56,742,000.00	64,283,913.00
210303	Цэвэр, бохир ус	1,965,388.00	65,888.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,910,900.00	52,561,553.00
210401	Бичиг хэрэг	4,310,700.00	2,397,460.00
210402	Тээвэр, шатахуун	20,752,380.00	29,450,943.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,938,900.00	2,581,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,908,920.00	18,131,550.00
2105	Нормативт зардал	100,775,087.78	117,077,264.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,032,391.28	100,224,163.17
210502	Хоол, хүнс	10,742,696.50	16,853,101.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,036,500.00	17,977,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,200,000.00	2,977,200.00
210604	Урсгал засвар	3,836,500.00	15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,893,000.00	6,024,000.00
210702	Дотоод албан томилолт	1,893,000.00	6,024,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,085,350.00	6,900,210.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,538,000.00	4,231,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	36,000.00	114,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,450.00	50,000.00
210807	Газрын төлбөр	207,900.00	208,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0	1,024,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,591,484.49	150,663,818.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,338,000.00	14,337,997.72
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,253,484.49	136,325,820.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,974,842.00	122,419,071.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,602,000.00	118,613,052.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	41,657,052.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	73,602,000.00	76,956,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,372,842.00	3,806,019.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,372,842.00	3,806,019.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>138,440,966.41</u>	<u>-342,140,686.15</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	3,489,750.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0	3,489,750.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0	-3,489,750.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>138,440,966.41</u>	<u>-345,630,436.23</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,260,213,565.73</u>	<u>1,708,178,214.06</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>105,602,000.00</u>	<u>120,268,783.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	105,602,000.00	120,268,783.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,602,000.00	120,268,783.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,602,000.00	120,268,783.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,154,611,565.73</u>	<u>1,587,909,431.06</u>
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,839,200.00	60,924,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,839,200.00	60,924,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,081,772,365.73	1,526,984,631.06
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,081,772,365.73	1,526,984,631.06
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,226,278,101.52</u>	<u>1,694,502,343.66</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,226,278,101.52</u>	<u>1,694,502,343.66</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,150,303,259.52</u>	<u>1,597,601,272.16</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,264,491.52	1,173,362,800.75
210101	Үндсэн цалин	485,812,591.29	588,833,663.63
210102	Нэмэгдэл	296,218,010.49	436,648,151.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,404,000.00	49,641,600.00
210104	Урамшуулал	46,829,889.74	98,239,385.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,934,200.00	153,727,201.70
210201	Тэтгэврийн даатгал	94,193,000.00	104,926,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,435,300.00	11,604,800.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,217,600.00	5,802,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,217,600.00	5,802,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,870,700.00	25,591,201.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,111,058.00	52,202,281.00
210301	Гэрэл, цахилгаан	5,403,670.00	7,566,993.00
210302	Түлш, халаалт	56,742,000.00	44,569,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,965,388.00	65,888.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,866,960.00	39,920,763.00
210401	Бичиг хэрэг	2,109,900.00	1,305,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,598,460.00	28,604,863.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,938,900.00	2,581,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,550,800.00	2,269,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,668,900.00	5,160,100.00
2105	Нормативт зардал	57,718,700.00	123,011,495.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,726,900.00	111,702,620.71
210502	Хоол, хүнс	9,191,800.00	11,308,875.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,517,100.00	27,927,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,200,000.00	2,977,200.00
210604	Урсгал засвар	10,017,100.00	24,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,893,000.00	6,024,000.00
210702	Дотоод албан томилолт	1,893,000.00	6,024,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,086,150.00	8,047,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,538,000.00	4,286,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	36,000.00	114,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,450.00	50,000.00
210807	Газрын төлбөр	207,900.00	208,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,800.00	2,116,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,911,600.00	13,377,860.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,911,600.00	13,377,860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,974,842.00	96,901,071.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,602,000.00	93,095,052.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	41,657,052.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	73,602,000.00	51,438,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,372,842.00	3,806,019.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,372,842.00	3,806,019.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>33,935,464.21</u>	<u>13,675,870.40</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	29,640,000.00	11,325,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,640,000.00	11,325,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,640,000.00	11,325,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,640,000.00	11,325,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-29,640,000.00</u>	<u>-11,325,700.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,295,464.21	2,350,170.40
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,957,261.63	35,252,725.84
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,252,725.84	37,602,896.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,055,456.71	1,542,355,243.20	2,066,695,253.91
Тайлант үеийн үр дүн	-	-	138,440,966.41	138,440,966.41
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,055,456.71	1,680,796,209.61	2,205,136,220.32
Тайлант үеийн үр дүн	-	-	-345,630,436.23	-345,630,436.23
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,284,554.00	89,055,456.71	1,335,165,773.38	1,859,505,784.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,629,806,300.00	1,647,253,414.06	-17,447,114.06	101.1
12	Татварын бус орлого	1,629,806,300.00	1,647,253,414.06	-17,447,114.06	101.1
120	Нийтлэг татварын бус орлого	76,764,900.00	120,268,783.00	-43,503,883.00	156.7
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	76,764,900.00	120,268,783.00	-43,503,883.00	156.7
122	Тусламжийн орлого	1,553,041,400.00	1,526,984,631.06	26,056,768.94	98.3
122001	Хандив тусламж /дотоод/	1,553,041,400.00	1,526,984,631.06	26,056,768.94	98.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,665,059,100.00	1,644,903,243.66	20,155,856.34	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,665,059,100.00	1,644,903,243.66	20,155,856.34	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,589,631,900.00	1,551,808,191.16	37,823,708.84	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,198,322,000.00	1,173,362,800.75	24,959,199.25	97.9
210101	Үндсэн цалин	522,433,900.00	588,833,663.63	-66,399,763.63	112.7
210102	Нэмэгдэл	514,771,200.00	436,648,151.25	78,123,048.75	84.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,610,000.00	49,641,600.00	3,968,400.00	92.6
210104	Урамшуулал	107,506,900.00	98,239,385.87	9,267,514.13	91.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,237,800.00	153,727,201.70	2,510,598.30	98.4
210201	Тэтгэврийн даатгал	105,108,300.00	104,926,400.00	181,900.00	99.8
210202	Тэтгэмжийн даатгал	12,782,400.00	11,604,800.00	1,177,600.00	90.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,391,200.00	5,802,400.00	588,800.00	90.8
210204	Ажилгүйдлийн даатгал	6,391,200.00	5,802,400.00	588,800.00	90.8
210205	Эрүүл мэндийн даатгал	25,564,700.00	25,591,201.70	-26,501.70	100.1
2104	Хангамж, бараа материалын зардал	42,030,600.00	39,920,763.00	2,109,837.00	95.0
210401	Бичиг хэрэг	2,133,100.00	1,305,000.00	828,100.00	61.2
210402	Тээвэр, шатахуун	29,489,700.00	28,604,863.00	884,837.00	97.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,938,900.00	2,581,600.00	357,300.00	87.8

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,269,200.00	2,269,200.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,199,700.00	5,160,100.00	39,600.00	99.2
2105	Нормативт зардал	128,206,600.00	123,011,495.71	5,195,104.29	95.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,560,600.00	111,702,620.71	3,857,979.29	96.7
210502	Хоол, хүнс	12,646,000.00	11,308,875.00	1,337,125.00	89.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,833,400.00	33,480,500.00	2,352,900.00	93.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,848,000.00	10,769,800.00	78,200.00	99.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,249,700.00	2,977,200.00	2,272,500.00	56.7
210604	Урсгал засвар	19,735,700.00	19,733,500.00	2,200.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	6,025,000.00	6,024,000.00	1,000.00	100.0
210702	Дотоод албан томилолт	6,025,000.00	6,024,000.00	1,000.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,276,500.00	8,047,670.00	228,830.00	97.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,286,200.00	4,286,200.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	120,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	114,510.00	5,490.00	95.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	208,000.00	208,000.00	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,340,300.00	2,116,960.00	223,340.00	90.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,700,000.00	14,233,760.00	466,240.00	96.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,700,000.00	14,233,760.00	466,240.00	96.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,427,200.00	93,095,052.50	-17,667,852.50	123.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,427,200.00	93,095,052.50	-17,667,852.50	123.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,207,200.00	41,657,052.50	7,550,147.50	84.7
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,920,000.00	51,438,000.00	-25,518,000.00	198.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	0.00	300,000.00	0.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-35,252,800.00	-2,350,170.40	-37,602,970.40	-6.7
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,252,800.00	2,350,170.40	37,602,970.40	-6.7
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	35,252,800.00	2,350,170.40	37,602,970.40	-6.7

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	35,252,725.84		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	37,602,896.24		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34	34		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	60,924,800.00	57,118,781.00	3,806,019.00	93.75
12	Татварын бус орлого	60,924,800.00	57,118,781.00	3,806,019.00	93.75
122	Тусламжийн орлого	60,924,800.00	57,118,781.00	3,806,019.00	93.75
122005	Төсвөөс санхүүжих	60,924,800.00	57,118,781.00	3,806,019.00	93.75
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,924,800.00	57,118,781.00	3,806,019.00	93.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,924,800.00	57,118,781.00	3,806,019.00	93.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,924,800.00	57,118,781.00	3,806,019.00	93.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,924,800.00	52,202,281.00	8,722,519.00	85.68
210301	Гэрэл, цахилгаан	11,438,800.00	7,566,993.00	3,871,807.00	66.15
210302	Түлш, халаалт	44,569,400.00	44,569,400.00	-	100.00
210303	Цэвэр бохир ус	-	65,888.00	(65,888.00)	
2106	Эд хогшил худалдан авах	4,916,600.00	4,916,500.00	100.00	100.00
210604	Урсгал засвар	4,916,600.00	4,916,500.00	100.00	100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 131,021.9 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчлийг илрүүлснээс 126,396.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1 зөрчилд зөвлөмж, шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой 1 зөрчил, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчилд тус тус албан шаардлага хүргүүлээ.

3.1 Залруулсан алдаа

Тус ЭМТ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэлтэй холбоотой дараах алдаа илэрснийг аудитын явцад залруулга хийсэн. Үүнд:

- Байгууллагын 2 ажилтанд 300.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгоод авлага үүсгээгүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4."үнэн зөв

байх; заалтад нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул авлагаар бүртгэж залруулсан.

- Хувь хүний орлогын албан татварын 1,562.5 мянган төгрөгийн татварыг өглөгөөр тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; заалтад нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул өглөг үүсгэж бүртгэсэн.
- Байгууллагын санхүүгийн тайланд туслах үйл ажиллагааны орлого 20,345,7 мянган төгрөгийг дутуу тайлагнасан ба нийт орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд буруу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх; заалтад нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул холбогдох дансанд бүртгэж залруулсан.
- Биетээр хүлээж аваагүй хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч, 4,265.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулж байгууллагын үр дүн бууруулж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт “үнэн зөв байх”-д нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,625.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17,943.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2 Албан шаардлага

1. Цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой 14,872.4 төгрөгийн эмийг Идэр фарм ХХК-аас худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн 14.4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” заалтад нийцэхгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэв.
2. Тус Эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэв

3.3 Зөвлөмж

Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 3,721.7 мянган төгрөгийг цалингийн бүлгээс, хоол хүнсний 903.7 мянган төгрөгийн зардлыг эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийн зардлаас тус тус гаргаж эдийн засгийн ангилал зөрчсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх”-ыг хэрэгжүүлж ажиллах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруула агүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын 2 ажилтанд урьдчилгаа олгоод авлага үүсгээгүй.	1	300.0	1	300.0			1	300.0		
Хувь хүний орлогын албан татварыг өглөг үүсгээгүй орхигдуулсан	1	1,562.5	1	1,562.5			1	1,562.5		
Эрүүл мэндийн газраас олгосон вакцины илүү цагийн хөлс, тэтгэвэрт гарсны болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн орлогыг буруу дансаар бүртгэсэн.	1	120,268.7			1	120,268.7	1	120,268.7		
Биетээр байхгүй 3 ширхэг зөөврийн компьютерт элэгдэл байгуулсныг залруулж, элэгдлийг зогсоон, анхны өртгөөр нь орлогод бүртгэсэн.	1	4,265.2			1	4,265.2	1	4,265.2		
Дүн	4	126,396.4	2	1,862.5	2	124,533.9	4	126,396.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил олгогчоос төлөх НДШ-ийн 3,721.7мянган төгрөгийг цалингийн бүлгээс, хоол хүнсний 903.7 мянган төгрөгийн зардлыг эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийн зардлаас гаргаж эдийн засгийн ангилал зөрчсөн	1	4,625.4					1	4,625.4
Дүн	1	4,625.4					1	4,625.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 2 удаагийн 24,650.0 мянган төгрөгийн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээллийг мэдээлээгүй, 8 удаагийн 74,473.4 мянган төгрөгийн 5 сая төгрөгөөс дээш зарлагын мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 11 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна	1	-			1	-		
Идэр фарм ХХК-иас 27.452.1 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслэл худалдан авснаас түүний дотор цахим дэлгүүрт байршсан 14,872.4 мянган төгрөгийн эм худалдан авсан зөрчил илэрсэн.	1	-			1	-		
Дүн	2	-			2	-		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			